

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

3-24

**1.Шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй
асуудал, шийдвэрлэх арга зам, бодлогын дэмжлэгийн
талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг
сонсох**

3-24

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны
06 дугаар сарын 25-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны дарга С.Зулпхар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 9 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 17 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Бум-Очир;
Чөлөөтэй: Ц.Баатархүү.

Нэг.Шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, бодлогын дэмжлэгийн талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ц.Намчинсүрэн, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч С.Дэмбэрэл, мөн академийн Тэргүүлэгчдийн газрын дарга А.Баярбаатар, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны дарга Б.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Б.Энхмаа байлцав.

Шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, бодлогын дэмжлэгийн талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Ц.Мөнхтуяа нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны дарга Б.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, С.Зулпхар нар үг хэлэв.

Дэд хорооны дарга С.Зулпхар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар мэдэгдэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, С.Зулпхар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, бодлогын дэмжлэгийн талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүүгийн хийсэн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 1 цаг 06 минут үргэлжилж, 9 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 13 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ДЭД ХОРООНЫ ДАРГА

С.ЗУЛПХАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 25-ны өдөр,

Пүрэв гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”

танхим

12 цаг 17 минут.

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДЭД
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

С.Зулпхар: Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны ээлжит хуралдаан өнөөдөр эхэлж байна. Дэд хорооны гишүүд 9 гишүүн байхаас одоо 6 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар, Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл, Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах, Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн, Улсын Их Хурлын гишүүн Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар нар хүрэлцэн ирсэн. Ирц 66.7 хувьтай байна. Ийнхүү Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны 2026 оны 06 сарын 25-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг бид танилцууллаа. Та бүхэнд хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр бид 2 асуудал. 2-мэдээлэл сонсох байгаа.

1 дүгээр асуудал Шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, бодлогын дэмжлэгийн талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны холбогдох албан тушаалтны мэдээллийг сонсоно.

Нөгөөтээгүүр бид “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх” Байнгын хорооны тогтоолын төслийг бас бэлэн болгосон байгаа. Энэ шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэх зорилго, бодлого, үйл ажиллагааны чиглэлээр энэхүү тогтоолын төслийг та бүхэнд бас урьдчилсан байдлаар тараасан.

Өнөөдөр бол бид тогтоолын төслийг танилцуулж, асуулт хариулт явна. Бид тогтоолын төслийг бол ирэх 7 хоногт Байнгын хороонд оруулахаар бас бэлтгэл хангах учиртай. Тэгэхээр та бүхэн бас саналаа өгнө гэсэн ийм чиглэлтэй байна. Одоо би мэдээлэл, шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, бодлогын дэмжлэгийн талаарх мэдээлэл хийнэ үү гэж Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргыг урьж байна.

Түүний өмнө би бас өнөөдрийн бидний хуралдаанд хүрэлцэн ирсэн албаны жишээ нь төлөөллийг танилцуулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч, академич С.Дэмбэрэл, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ц.Намчинсүрэн, Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газрын дарга Баярбаатар, Үндэсний шинжлэх ухаан, технологийн

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Албаны дарга Б.Бат-Эрдэнэ гэсэн ийм бүрэлдэхүүн байна. Би Батхүү даргыг микрофонд урьж байна. Мэдээллээ хийнэ үү гэж.

Ажлын хэсгийн микрофон дээр очих юм байна Батхүү дарга,

И.Батхүү: Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны дарга гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Шинжлэх ухаан, технологийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, бодлогын шийдлийн талаар танилцуулга бэлдэж ирсэн байгаа.

Өнөөдөр Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн 20 гаруй хууль тогтоомж, дүрэм, журам энэ салбарт үйлчилж байгаа. Гол суурь хууль тогтоомж, эрх зүйн актыг дурдвал хамгийн сүүлд 2024 онд Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. 1998 онд Технологи дамжуулах тухай хууль, 2012 онд Инновацийн тухай хууль, 2021 онд Патентын тухай хууль, 2020 онд Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, 2022 онд Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих, журам, 2023 онд шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтыг тус тус батлуулж, хүчин төгөлдөр мөрдөж ирсэн.

2024 онд Монгол Улсын Их Хурлаар Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2.2-т заасан шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бэхжүүлээд зогсохгүй Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Алсын хараа 2050”-д заасан шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлийн нэг болгон хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог бүрдүүлэхэд чиглүүлэн мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог бүрдүүлж, судалгаа, хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэр, тогтолцоо бүхий төр, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчныг бий болгоно гэсэн зорилт, мөн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлж, оюуны өмч, шинэ технологийг үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг нээн Дэлхийн мэдлэгийн индексийг 52.4 оноонд хүргэнэ гэсэн зорилт, мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлтийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 1 хувьд хүргэж, шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлэх, улмаар оюуны өмч, шинэ технологийг эдийн засгийн эргэлтэд оруулж, инновац, технологид суурилсан салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлнэ гэсэн бодлогын зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал түлхэц болсон.

Тус хуулиар шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлага, бүтэц, оролцоог шинэчилж, оролцогчдын эрх, үүргийг оновчтой тогтоон, нийгэм, эдийн засгийн хөгжил, хүний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн тогтолцоог бүрдүүлэх суурь зарчмыг тодорхойлсон. Төр, хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүүжилтийг олон эх үүсвэртэй, ил тод, үр дүнд суурилсан хэлбэрт шилжүүлэх боломжийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Түрүүн дурдсанаар Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн баримт бичигт шинжлэх ухаан, технологи, инновац, нийгэм эдийн засагт оруулах хувь нэмрийг үндэсний хэмжээний үр дүн, салбарын үр дүн, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн байдлаар тодорхойлсноороо онцлог бөгөөд 2030 он гэхэд дэлхийн мэдлэгийн индексээр Монгол Улсын эзлэх байрыг 4.8 оноогоор нэмэгдүүлж, 52.4-д хүргэх инновацийн индексээр одоогийн байгаа байрыг 28 байраар урагшлуулж, 50-д эрэмбэлэгдэх судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон оюуны өмчийг эдийн засагт эргэлтэд оруулах замаар лиценз, роялтигийн төлбөрөөс ашиг хүртэх хувь, хэмжээг тооцдог болох. Мөн 2030 он гэхэд одоогийн тооцох түвшнээс 25 хувиар нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

Ингэхдээ бүх салбарт шинжлэх ухаан, технологийн оролцоог жигд хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар салбар, салбар дундын судалгаа, хөгжүүлэлтийг харилцан дэмжих, хамтын ажиллагааг илүү нягтаршуулах, цаашдаа шинжлэх ухаан, технологийн дэд бүтэц, судалгааны орчин нөхцөл, лабораторийн хүртээмжийг харилцан үр ашигтайгаар ашиглах боломжийг бүрдүүлэх, судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон оюуны өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, технологи дамжуулалт, технологи нутагшуулах ажлыг хувийн хэвшлийн эрэлтэд суурилсан нь суурилан дэмжихэд чиглүүлэхээр арга замыг нь тодорхойлж, бодлогын дэмжлэг үзүүлэхээр төлөвлөсөн.

Нөгөөтээгүүр төр, хувийн хэвшлийн судалгаа, хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг олон эх үүсвэр тогтолцоонд шилжүүлэх чиглэл, гааль, татварын бодлогоор дэмжих, улсын төсөв болон аймаг, орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөр, хөгжлийн түнш байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачдын оролцоо, хамтын ажиллагааг хангахад чиглэсэн бодлогын дэмжлэг үзүүлнэ. Үр дүнд нь 2030 он гэхэд ДНБ судалгаа хөгжүүлэлтийн зардлын эзлэх хувь зорилтот түвшин болох 2 хувьд хүрэх бүрэн боломжтой гэж харж байна.

2 дугаарт санхүүжилтийн олон эх үүсвэрийг бүрдүүлснээр судалгаа, хөгжүүлэлтийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар олон улсын судалгаанд оролцох гадаадын эрдэмтэн, судлаачтай харилцан туршлага солилцох, хамтарсан судалгаа хийх өндөр өртөг бүхий судалгааны лаборатори, тоног төхөөрөмжийг дундын ашиглалттай эдийн засгийн үр өгөөжтэй байлгах. Ингэснээр судлаачдын бүтээлийн чанар сайжирч, 2030 он гэхэд олон улсын хянан магадалгаатай мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо 1.5 дахин нэмэгдэж, эдийн засгийн эргэлтэд орсон оюуны өмчийн үнэлэмж, үнэ цэн улам бүүр өсөн нэмэгдэнэ гэж тооцсон.

Өнөөдөр бидэнд тулгамдаад байгаа маш олон асуудлууд, тухайлбал, эрчим хүч, хог хаягдал, утаа, түгжрэл зэрэг асуудлыг шийдвэрлэхэд салбар дундын уялдааг хангасан шинжлэх ухааны үндэслэл, нотолгоонд суурилсан бодлого, шийдэл зайлшгүй хэрэгтэй байгаа.

Иймд шинжлэх ухааны салбарын нөөц бололцоог ашиглан эрчим хүч, байгаль орчин, уул уурхай, аялал жуулчлал, аж үйлдвэр, эрдэс баялаг, хөдөө аж ахуй, бусад дэд бүтцийн салбар дундын бодлогын уялдааг бэхжүүлэх, хэрэгжилтийн зохицуулалтыг хангах бүрэн нөөц боломж байгаа.

Дээр дурдсан бодлого, зохицуулалтыг хангахад өнөөдөр шинжлэх ухаан, технологийн салбарт дараах нөөц боломж байгааг бүтэц, зохион байгуулалтын хувьд авч үзэх юм бол Монгол улсын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь Улсын Их Хурал, Засгийн газар, Шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний хороо, шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, Шинжлэх ухааны академи, яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын салбар зөвлөл, аймаг, нийслэлийн шинжлэх ухаан, технологи, инновацын дэд зөвлөл, эрдэм шинжилгээний байгууллага нь өөрийн удирдлагын байгууллагаас бүрдэж байна.

Шинжлэх ухаан, технологийн салбарт нийт 66 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төв, эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллагууд шинжлэх ухааны үйл ажиллагаанд тогтмол оролцож, шинжлэх ухаан, технологи, инновац, судалгааг хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж ирсэн. Үүнд:

Яам, агентлагийн харьяа 17, Шинжлэх ухааны академийн харьяа 16, эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын 30, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн дэргэдэх 3 хүрээлэн төв үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагад нийт 6919 ажилтан ажиллаж байгаагаас 4564 нь үндсэн ажилтан, үүний 1754 нь эрдэм, шинжилгээний ажилтан байна.

Нийт судлаачдын дотор 3106 буюу 57 хувь нь эрдмийн зэрэг цолтой академич 64, шинжлэх ухааны доктор 108, боловсролын доктор 1847, профессор 383, дэд профессор 704 байна.

1990 оны үетэй харьцуулахад салбарт ажиллагсдын тоо 3 дахин буурсан. Монгол Улсын 1 сая хүнд ноогдох эрдэм, шинжилгээний ажилтны тоогоор Азийн дунджаас 3 дахин, дэлхийн цөөн хүн амтай улсын нэг Финлянд улсаас 14 дахин доогуур байна.

Иймд 1 дүгээрт бүтэн цагаар ажилладаг эрдэм, шинжилгээний ажилтны тоог Ази тивийн дундаж түвшинд ойртуулах.

2 дугаарт эрдэм, шинжилгээний ажилтан, судлаачдын нийгмийн баталгаа, цалин хангамж, өнөөдрийн үнийн өсөлт, инфляцтай уялдахгүй, амьдралд нь хүрэлцэхгүй байдлаас шалтгаалан чадварлаг залуу эрдэмтэн, судлаачдыг гадаад руу алдах, өөр бусад өндөр цалинтай хувийн хэвшлийн ажлын байранд шилжин ажиллах зэрэг асуудал сүүлийн 3 жилд ажиглагдаж байгаа нь энэ салбарын нэн тэргүүнд шийдвэрлэх тулгамдсан асуудал болоод байна.

Судалгаа, хөгжүүлэлтийн чанар, хүртээмж салбарын нийт бүтээмжид сөрөг нөлөө үзүүлж, боловсон хүчний дутагдалд орох эрсдэлийг ч цаашид бий болгож байна.

Гэхдээ Монгол Улсын Засгийн газраас бодлогын арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлснээр Засгийн газрын 2023 оны Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 241 дүгээр тогтоолоор салбарын цалингийн системд өөрчлөлт оруулж, ТҮШҮ ангиллын

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

шатлалыг байхгүй болгож, ангилал тус бүрийн цалингийн доод хэмжээг өмнөх сүлжээний 5 дугаар шатлалын түвшинд тогтоож өгснөөр албан хаагч нь ажлын үр дүнгээрээ цалинжих боломжийг бүрдүүлсэн.

Мөн Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоолын дагуу салбарын албан хаагчдын цалинг 15 хувиар нэмж шийдвэрлэсэн. Улмаар Эдийн засаг, хөгжлийн яам болон Монголын боловсрол шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо хооронд 2026-2028 оны хамтын хэлэлцээрт салбарын албан хаагчдын цалинг 2027 онд 3.5 сая төгрөгт хүргэхээр тусгасан зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг тасралтгүй авч хэрэгжүүлж явж байна.

Эндээс дүгнэхэд Монгол Улс 1990 онд судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд ДНБ 1 хувийг зарцуулж ирээдүйд 3 хувьд хүргэх зорилт дэвшүүлж байсан. Гэвч салбарын санхүүжилтийн ДНБ-ий эзлэх хувь сүүлийн 10 жилд ч өсөөгүй буюу 0.1 хувь орчим болтлоо буурсан нь шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалт туйлын хангалтгүй байгааг илтгэж байна.

Тухайлбал, 2024 онд шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь дэлхийн дунджаас 15-20 дахин бага үзүүлэлттэй байгаа гэсэн тооцоолол бий. Үүнээс гадна Монгол Улсын экспортод гаргаж буй бүтээгдэхүүний технол.../минут дуусав./

С.Зулпхар: Батхүү даргын цагийг жоохон нэмж өгье, мэдээллээ бүрэн сонсьё.

И.Батхүү: Монгол Улсын экспортод гаргаж буй бүтээгдэхүүний технологийн хангамжийн түвшнийг авч үзвэл түүхий эдийн нөөцийг боловсруулсан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх техник, технологийн түвшин хангалтгүй, эдийн засгийн чадавх сул байгаагаас технологийн агууламжгүй бүтээгдэхүүн, нам технологийн бүтээгдэхүүн дийлэнх хувийг эзэлж байна.

Мөн өндөр технологи нь үйлдвэрлэл, оюуны өмч, патентын үнэ цэн сул байгаагаас Монгол Улс 2025 онд инновацын индексээр 7 байр ухарч, 78 дугаар байрт, мэдлэгийн индексээр 65 дугаар байрт жагссан байна.

Үүний зэрэгцээ шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа нь гадаадын хамтын ажиллагаа, ялангуяа хамтарсан судалгаа, хөгжүүлэлт буюу төсөл, хөтөлбөрийн үүрэг маш чухал байдаг. Мэдлэг технологи дамжуулах гол арга замын нэг хамтарсан төслийн хүрээнд Монгол судлаачдын олон улсын судалгаанд оролцох олон улсын нэр хүндтэй сэтгүүлийн судалгааны үр дүнгээр өгүүлэл хэвлүүлэхээс эхлээд судалгааны олон улсын шинэ мэдлэг, технологи, арга зүйд суралцах, харилцан туршлага солилцох, мэдлэг хуваалцах боломж бүрддэг.

Шинжлэх ухааны технологийн салбарт ОХУ, БНХАУ Бүгд Найрамдах Беларусь Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс зэрэг улс орнуудтай Засгийн газар төрийн байгууллагын хооронд санамж бичгийн хүрээнд хамтарсан судалгааны төслүүдийг сүүлийн 5 жилд тогтвортой хэрэгжүүлж ирсэн.

Эдгээр хамтарсан төслийг байгаль, нийгэм, хүмүүнлэг, анагаах инженер, технологи, хөдөө аж ахуй гэсэн шинжлэх ухааны 6 салбарт чиглэлээр хэрэгжүүлж

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

байгаа. Монгол Улсын талаас нэг судалгаанд дунджаар 80 сая төгрөгийн санхүүжилтийг олгож байна.

Иймд “Алсын хараа 2050” Засгийн газрын 24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 26-30 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилтыг хангах зорилгоор эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх шинжлэх ухаан, технологи, инновацын хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлэх чиглэлд судалгаа хөгжүүлэлтийн зардлын ДНБ-ий эзлэх хувийг 2029 он гэхэд 1.5, 30 он гэхэд 2 хувьд хүрэхээр тооцоолж жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байгаа ч нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж, зорилтот түвшинд хүрсэн санхүүжилт батлагдахгүй байна.

2026 онд шинжлэх ухааны салбарын санхүүжилт 156.4 тэрбум төгрөг, үүнээс 55.1 хувь буюу 86.3 тэрбум төгрөг нь урсгал зардал, 37.4 хувь буюу 58.6 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт, 0.9 хувь буюу 1.5 тэрбум төгрөг нь Монгол Улс судлалыг дэмжих үйл ажиллагааны зардал, 6.4 хувь буюу 10 тэрбум төгрөг нь судалгаа хөгжүүлэлтийн шууд зарцуулж байгаа нь судалгааны ажлын бодит хэрэгжилт чиглэж буй санхүүжилтийн хэмжээ харьцангуй бага байгааг харуулж байна.

Сүүлийн 10 жилд эрдэм шинжилгээний ажлын зардал тогтмол 10-аас 12 тэрбум орчим төгрөг, нэг судалгаанд дунджаар 15-19 сая төгрөг ногдож байгаа нь судалгааны чанар үр дүн салбар бүрд очих хүртээмж өгөөж хангалтгүй байх үндсэн шалтгаан болсон.

Харин шинжлэх ухаан, технологийн салбар сүүлийн 5 жил хийгдсэн хамгийн том хөрөнгө оруулалт болох эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор нийт 4.8 га газар, 74300 квадрат метр ашиглалтын талбайтай олон улсын стандартад нийцсэн лаборатори, оффис, музей, спорт заал бүхий 3300 орчим эрдэмтэн судлаач, албан хаагчид ажиллах шинжлэх ухаан, инновац, технологи, танин мэдэхүйн цогцолбор бүхий орчин үеийн жишиг барилга, байгууламжийг барьж явж байна.

Өнөөдрийн байдлаар тус барилга байгууламжийн нийт ажлын гүйцэтгэл 71.4 хувьтай үргэлжилж байна. Цогцолборын барилгатай холбоотойгоор салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ жилд 5-24 тэрбум төгрөг болж нэмэгдсэн боловч судалгааны ажилд амин чухал шаардлагатай лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл их засварын сүүлийн 30 жилд бараг хийгдээгүй. Үүнээс хамаарч хүрээлэнгүүдийн багаж, тоног төхөөрөмжийн 80 гаруй хувь нь 1990 оноос өмнө ашиглаж байсан багаж, тоног төхөөрөмж байгаа нь гаргаж авсан үр дүнг, судалгааны үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүл хүлээн зөвшөөрөхгүй байх нөхцөлд хүргээд байна.

Иймд шинжлэх ухааны паркийг байгуулах шаардлагатай 30 тэрбум, төрөлжсөн гений сан байгуулах шаардлагатай 3 тэрбум, супер компьютерын хүчин чадлыг нэмэгдүүлэх 9 тэрбум, эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн сан байгуулах 3 тэрбум, нийт 45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг ойрын хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байна.

2 дахь агуулга буюу салбар тулгамдаад байгаа асуудлын талаарх баримтыг тоймлон авч үзвэл 1 дүгээрт нийгэм, эдийн засгийн хөгжил маш хурдацтай

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үргэлжилж байгаа өнөө үед мэдлэгийг шуурхай ашиглах дадал, чадвар бүхий өндөр мэргэжил нь баялгийг бий болгох, тухайн хувь хүн болон байгууллагын нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлох хамгийн гол нөөц хүчин зүйл болж байгаа ч Монгол улсын шинжлэх ухаан, технологийн салбарын дэлхийн болон бүс нутгийн шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын өнөөгийн түвшин үндэсний эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр хангалтгүй хэвээр байна.

Монгол Улсын ДНБ-д импортын эзлэх хувь дунд, бага орлоготой, бусад орныхоос өндөр байгаа нь шинээр бий болгож байгаа нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүн харьцангуй бага үндэсний эдийн засаг, гаднын технологиос бүрэн хамааралтайг харуулж байна.

2 дугаарт, боловсрол, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг дэмжсэн эдийн засгийн хөшүүрэг хангалтгүй байна.

3 дугаарт, сүүлийн 30 жил гаруй салбарын санхүүжилт ,хөрөнгө оруулалт туйлын хангалтгүй байна.

4 дүгээрт, Шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалтыг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээс бус төсвийн бус бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх боломжийг зайлшгүй нээх шаардлага тулгараад байна.

5 дугаарт, төрийн өмчийн лабораторийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, нээлттэй дундын ашиглалтын хэлбэрээр үйл ажиллагааг явуулах, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

6 дугаарт, шинжлэх ухаан, технологийн хөгжил, эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн ч үйл ажиллагаанд нь төрийн оролцоо хэт давамгайлсан хувь, төрийн хэвшлийн оролцоо хангалтгүй, хамтын ажиллагаа салбар бүрд жигд бус, дутмаг байна.

7 дугаарт, судалгаа, хөгжүүлэлтийн санхүүжилт бага, хүний нөөцийн хүрэлцээ, цалин хөлс, нийгмийн баталгаа хангалтгүй зэрэг хүчин зүйлээс хамаарч бүх салбарт судалгааны ажлын цар хүрээ, үр дүн хязгаарлагдмал, үр өгөөж нь улс орны хөгжил шийдвэрлэх ач холбогдол оролцож чадахгүй нөхцөл байдалтай байна.

8 дугаарт, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг зөвхөн их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд хариуцуулж улсын төсвөөс санхүүжүүлэх нь үр ашиг бага байгаа учраас томоохон компани хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааг нэмэгдүүлж, эдийн засгийн хөшүүрэг оновчтой ашиглах шаардлагатай байна.

9 дүгээрт, гадаадын хамтарсан төсөл, хөтөлбөрийг шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх шинэ мэдлэг технологид нэвтрэх арга зам, төсвийн бус санхүүжилтийн чухал эх үүсвэр хэмээн үзэж бүх талаар дэмжиж, шийдвэрлэх нь чухал байна.

Иймд бодлогын хувьд энд харуулж буй 6 шинэчлэлтийг хийх, тэдгээр шаардлагад төсөв санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл, олон улсын

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр, хөгжлийн түнш байгууллагын дэмжлэгтэйгээр авч хэрэгжүүлэхэд Улсын Их Хурал, Засгийн газар, яам, салбарын байгууллагад хамтран ажиллах, онцгойлон анхаарах нь чухал шаардлагатай байна.

Дээрх 6 шинэчлэлийг авч үзэхдээ Үндсэн хуулийн 38.2.2-т заасан шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар тогтоосон шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөр, шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасан шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг дээр дурдсан зорилгод чиглүүлэн боловсруулж батлуулах, шаардлагатай төсөв, санхүүжилтийг бүх талаас дэмжих шаардлагатайг онцлон хэлье.

Энэ тал дээр та бүгдийг дэмжиж ажиллахыг хүсье. Баярлалаа.

С.Зулпхар: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүүд мэдээлэл хийсэнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд мэдээлэлтэй холбогдуулж асуулт асууна. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Мөнхтуяа гишүүнээр тасалъя. Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын Байнгын хорооны, манай Байнгын хорооны тогтоол гарах юм байна гэж ойлголоо. Тэгээд ер нь энэ ДНБ-ий 1-ээс доошгүй хувийг шинжлэх ухааны салбарт зарцуулах ёстой гэсэн ийм олон улсын туршлагууд ч байдаг. Тэгээд манайх бол мэдээж зарцуулж чадахгүй байгаа л даа. 1 хувиа, 1 хувь хүртэл.

Жишээлбэл Монгол Улсын ДНБ-ийг 90 их, энэ жил 90 орчим их наяд байгаа байх тийм ээ? Тэгэхээр 90 их наяд гэж тооцвол 1 хувь нь 900 тэрбум болох байх тээ? Тэгэхтэйгээ зэрэг бид нар бол сая 2, 3 жилийн өмнөөс шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн парк гэж л 100 хэдэн тэрбумын хөрөнгө оруулалт, барилга байшин яг хөрөнгө оруулалт талд хөрөнгө оруулалт хийж байгаагаас биш бусад тоног төхөөрөмж ер нь энэ боловсон хүчний нийгмийн баталгаа гээд л ингээд л олон асуудал дээр ер нь нэлээн хоцрогдсон ийм байдалтай байгаа.

Тэгээд сая 2 жилийн өмнө шинжлэх ухааны салбар маань Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд очсон. Хуучин бол Боловсролын яаманд харьяалагддаг байсан бол. Тэгээд би бол уг нь 2 жилийн өмнө харахдаа энэ цаашдаа улс орны энэ эдийн засаг, энэ хөгжлийн том асуудлууд энэ юман дээр бас энэ шинжлэх ухаанч байя. Ер нь шинжлэх ухааны салбараа түшиглэе гэж ингэж харж байгаа юм байна. Тэгээд энэ Эдийн засаг, хөгжлийн яам дэргэдээ авч байгаа юм байна гэж ингэж ойлгосон. Сүүлийн үеийн энэ яригдаж байгаа том том асуудлууд, энэ юмнууд дээр харж байхад энэ нөгөө шинжлэх ухаан маань их үүрэг рольтой биш л харагдаад байна л даа. Нөгөө л популизм, нөгөө л олонх, нөгөө л өнөөгийн нөхцөл байдал, олонхын массыг дагасан байдлаараа л шийдвэр гаргаад яваад байна.

Тэгэхээр ер нь яг энэ Эдийн засаг, хөгжлийн яам цаашдаа энэ аливаа энэ улс орны хөгжлийн бодлоготой холбоотой том асуудлууд дээр энэ шинжлэх ухааны яг судалгаа, энэ шинжлэх ухааны байгууллагадаа түшиглэх энэ эрдэмтэн,

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

судлаачид энэ шинжлэх ухааны байгууллагынхныхаа үгийг сонсох, эднийхээ санаа оноог тусгах тал дээр ер нь яг яам ямар бодлого барьж байгаа вэ гээд. Тэгээд бид нар бол цаашдаа мэдээж энэ тогтоол гараад ер нь ДНБ-ийхээ 1 хувь хүртэл, 1-ээс доошгүй хувийг бол энэ шинжлэх ухааны салбарт оруулж байх хэрэгтэй. Ингэж байж энэ цаашдаа шинжлэх ухааны салбарынхныхаа үгийг сонссоноор эдийн засгийн хэмнэлт гарна. Мөн аливаа ажил дэс дараатай, бүтээлч, бүтээмжтэй ийм явах юм.

Тэгэхгүй бол одоо ерөөсөө дандаа л популизмаар ямар ч шинжлэх ухаанч бишээр энэ асуудалд хандаад байгаа зүйлүүд бас байна гэдгийг хэлье. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яам, ер нь энэ хөгжлийн бодлого, төлөвлөлт, энэ юман дээрээ энэ шинжлэх ухаанд хэр ер нь шинжлэх ухаанч хандаж байгаа юм бэ, ер нь цаашдаа ямар бодлого байгаа юм бэ гэдэг дээр хариулт өгчихвөл сайн байна.

С.Зулпхар: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү дарга хариулъя.

И.Батхүү: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Эдийн засаг, хөгжлийн яамны хүрээнд шинжлэх ухааны салбар шилжин ирсэнтэй холбоотой Эдийн засгийн хөгжлийн яамны хуулиар хүлээсэн Засгийн газрын тухай хуулиар хүлээсэн чиг үүрэг байгаа. Салбар тус бүрийн болон салбар дундын зохицуулалттай холбоотой бодлогын реформуудыг хийх.

Ялангуяа дунд хугацааны, богино хугацааны улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулахад шинжлэх ухааны салбарын эрдэмтдийн оролцоог маш сайн хангаж байгаа. Өнгөрсөн хугацаанд 26-30 оны хөгжлийн үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулах батлуулахад Шинжлэх ухааны академи, хүрээлэнгүүдийн эрдэмтдийн зөвлөлөөр удаа дараа хэлэлцүүлж, шүүмжийг явуулж тусгаж ажилласан.

Дээр нь бас салбар салбарын, хөдөө аж ахуй, газар тариалан, боловсрол гээд бусад салбар дээр явагдаж байгаа аливаа Засгийн газарт оруулж байгаа бодлогын шийдэл, яамны зүгээс өгч байгаа санал дээр байнга шинжлэх ухааны салбарын оролцоог хангаж ажиллаж байгаа. Мэдээж энийг тогтолцооны хувьд шилжиж ирснээс энэ шинжлэх ухааны салбарын хуримтлагдсан мэдлэг, туршлага, өнгөрсөн хугацаанд бий болсон зөвлөмжүүдийг үндэсний хэмжээний асуудал болгож гаргаж ярих, баримт нотолгоонд суурилсан байдлаар асуудалд хандах хандлагыг бол бодитой хэрэгжүүлж чадаж байгаа гэж харж байгаа.

Яах вэ нийгмийн сүлжээ, олон нийтийн анхааралд байдаг тодорхой сэдвүүд дээр шинжлэх ухаанч бус хандлагаар хандаж байгаа тодорхой хүмүүсийн гаргаж байгаа нөлөөллийг нийгэмд зөв ойлгуулах, энэ нь буруу юм, бодит байдалтай нийцэхгүй байна, энэ чинь яг шинжлэх ухаан талаасаа ийм ийм нөлөөтэй байдаг юм гэдэг тал дээр бас манай холбогдох хүрээлэн, эрдэмтэн судлаачид маань дуу хоолойгоо гаргаад идэвхтэй оролцох ёстой гэж ойлгож байгаа. Энэ дээр бол тантай санал нэг байгаа.

С.Зулпхар: Хосбаяр гишүүн тодруулъя.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Г.Хосбаяр: Тийм саяхан нөгөө 27 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө орж ирсэн шүү дээ. Тэгээд зүгээр тэн дээрээс харж байхад жишээлбэл бүсчилсэн хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийг яаж дэмжих юм бэ гээд харахад л жишээлбэл хангайн бүсэд уламжлалт мал аж ахуйд суурилсан бүс байна гэхчхэн байгаа юм. Тэгснээ хийх ажил гэсэн чинь 108 худаг гаргана. Зөвхөн тэр бүсийн хөгжил, тэр мал аж ахуйн, уламжлалт мал аж ахуйн хөгжилд худаг гаргаад л бараг 27 онд хөгжих юм биччихсэн байх жишээний.

Тэгээд ер нь энэ улсын төсөв, энэ татвар хувь, нийгмийн даатгалын шимтгэл ч юм уу бууруулах, энэ орлого бүрдүүлэлт гээд олон юман дээр бас танайх энэ шинжлэх ухааны эрдэмтэн судлаачдынхаа гаргасан тайлан, мэдээ ер нь бодлого юмыг бас сайн дагуулж хэлж ярьж баймаар юм байна лээ шүү гэдгийг би бас Эдийн засгийн хөгжлийн яамныханд хэлэх гээд байгаа юм.

Тэгэхгүй бол хэтэрхий ингээд олон нийтийг дагасан, хар массыг дагасан бас ийм шинжлэх ухаанч биш мэдээллээр шийдвэр гаргаад гишүүдийг ч гэсэндээ ингээд байдалд оруулаад шахаад байдаг зүйл аж.../минут дуусав./

С.Зулпхар: Хосбаяр гишүүн санал хэллээ гэж ойлгов уу зөв үү? Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Манайх бол ер нь сүүлийн 30 гаруй жилд энэ боловсрол, шинжлэх ухаан гэсэн энэ 2 гол том салбараа бол орхигдуулаад ирсэн нь бол үнэн. Энэ эрдэмтэд маань бараг ажил хийхэд маш хүнд байгаа. Энийг бол хаа хаанаа бид нар бүгд ойлгож байгаа. Тэгээд уг нь би сайдаас 3 асуулт асууна гэсэн байхгүй байнаб Тэгэхдээ яах вэ асуучихъя.

Монгол улс 1990 онд судалгаа хөгжүүлэлтийн зардлыг ДНБ-ий 1 хувьд хүргэнэ гэсэн зорилт тавьж байсан. Өнөөдөр энэ үзүүлэлт 0.1-ээс 0.15 хувь орчимд л гацаад байна л даа. Алсын хараа-2050, 2026-аас 30 оны үндсэн чиглэлд ДНБ-ий 2 хувьд хүргэнэ гэж заагаад өгчихсөн байгаа. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд 27, 28, 29 онуудад жил бүр хэдэн төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоолол хийсэн бэ? 27, 28, 29 онд. 30 онд 2 хувьд хүргэе гээд байна шүү дээ ДНБ-ий. Эсвэл энэ зөвхөн бодлогын баримт бичиг дээр үлдэх зүгээр л ийм тоо болоод үлдэх үү гэдгийг би энэ Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууж байгаа юм.

2 дугаарт нь судлаачдын хүний нөөцийн тухай асуулт асууя. Энэ дээр бас та нар бас сая хэлж байна л даа Азийн дунджаас 3 дахин бага байна эрдэмтдийнхээ тоогоор гэж байна. Тэгвэл Монгол Улс 1 сая хүн амд ногдох эрдэм, шинжилгээний ажилтны тоогоор Азийн дунджаас ийм бага байна. Финляндаас бол бүүр 14 дахин доогуур байна. Харин судлаачдын цалин амьжиргаанд хүрэхгүй байгаа учраас залуу эрдэмтэд хувийн хэвшил болон гадаад улс руу шилжиж байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам 27 онд судлаачдын дундаж цалинг 3.5 сая төгрөгт хүргэхээс өөр ямар бодит арга хэмжээ авч байгаа вэ? Жишээ нь судлаачдын орон сууц, эрүүл мэнд, тэтгэврийн нас гээд, тэтгэвэр гэх мэт тусгай бодлого боловсруулж ажиллаж байна уу?

3 дугаарт нь судалгааны үр дүнгийн өгөөжийн тухай өнгөрсөн 30 гаруй жилд 4244 төсөлд 178.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Гэвч Монгол Улсын Дэлхийн инновацын индексийн байр 20 онд 58 байсан бол 25 онд 78 болж,

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

20 байраар арагш ухарсан байна. Судалгаанд зарцуулсан төсвөөс хэдэн төгрөгийн эдийн засгийн өгөөж бий болсон нь, мөн Засгийн газрын тооцоо гаргасан уу? Хэрвээ үгүй бол төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн судалгааны ажлын үр өгөөжийг хэрхэн хэмжих вэ? Одоо бид нар чинь сүүлийн үед их л ажлаа хэмжиж гаргаж ирнэ гээд ярь.../минут дуусав./

С.Зулпхар: Асуулт гүйцээе.

Ц.Мөнхтуяа: Энэ 178.6 тэрбум төгрөг зарцуулсан ч инновацын индекс 20 байраар ухарсан энэ хариуцлагыг хэн хүлээх вэ? Ийм 3 асуулт байна.

С.Зулпхар: Эдийн засаг, хөгжлийн Төрийн нарийн бичгийн дарга Батхүү хариулъя.

И.Батхүү: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Түрүүнд дурдсан 2 хувьд хүргэх зорилго гэдэг маань ДНБ тухай тухайн жилүүддээ төсвийн хүрээгээ дагаад төсвөө тооцоолоод батлагдаад явахад хувь, хэмжээгээр явна гэсэн үг. энэ 2026 оны байдлаар жишээ нь ДНБ 100 тэрбум, 100 их наяд төгрөг дөхлөө гэхэд тооцоолоод үзэх юм бол 2 их наяд руу дөхнө гэсэн үг.

Гэхдээ харамсалтай нь яг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө төсвийн төсөөллийг өргөн бариад хэлэлцүүлгийн явцад янз бүрийн шалтгаанаар хязгаарлагдмал нөөц маань яг энэ төлөвлөсөн хэмжээнд батлагдахгүй нөхцөл байдал үүсдэг. Мөн эдийн засгийн гадаад шокоос шалтгаалаад тухайн жилд бас төсвийн тодотгол орох үед бас тодорхой урсгал зардлын өсөлтийг шингээх нөхцөл шаардлагууд үүсэх үедээ яг төлөвлөсөн ажлуудын маань санхүүжилт хангалттай хэмжээнд тавигддаггүй, батлагддаггүй нөхцөл байдлууд үүсдэг. Энэнээс шалтгаалаад бас тухайн тухайн жилүүдийн зорилтууд ухарч, үр дүн нь сул гардаг ийм нөхцөл байдал үүсэж байгаа.

Шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, албан хаагчдын цалинтай холбоотой асуудлыг өнгөрсөн онд боловсрол, эрүүл мэндийн салбарын асуудал яригдахад шинжлэх ухааны салбарыг бас орхигдуулж болохгүй гээд Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс оруулсан. 26 онд бол 15 хувиар нэмэгдүүлчихсэн одоо үйлчлээд явж байгаа. Мөн үйлдвэрчний эвлэлтэй бас, салбарын үйлдвэрчний эвлэлтэй хийсэн хэлэлцээрээр бас 3.5 сая төгрөгт хүргэе гээд тохиролцчихсон явж байгаа. Цааш цаашдын төсөв батлагдах, одоо энэ Их Хурлын тогтоолын төсөлд ч гэсэн энэ асуудлаар чиглэл нь тусчихсан байгаа. Энэ дээр анхаарч ажиллана.

Эрдэм шинжилгээний ажилтнуудын ажиллах нөхцөл байдалтай холбоотойгоор бас бид нар арга хэмжээ авч ажиллаж байгаа. Жишээлбэл, нийслэл дээр хэрэгжиж байгаа тэр орон сууцын төслүүдийн төслийн нэгж холбогдох албан хаагчидтай яамны зүгээс уулзалт зохион байгуулаад албан ёсоор хүсэлт тавьсан эрдэм шинжилгээний ажилтнуудыг энэ хөтөлбөртөө хамрагдуулж өгөөч ээ, орон сууцын хангамж дээр анхаарч өгөөч гээд яриад явж байгаа.

Мөн түрүүн дурдсан шинжлэх ухааны нэгдсэн цогцолборын хүрээнд ч гэсэн бас шинжлэх ухааны албан хаагчдын ажиллах орчин бас нийгмийн асуудлыг шийдвэрлэх объектууд бас тусаад хэрэгжээд явж байгаа.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Цаашилбал ер нь эрдэм шинжилгээний ажлыг зөвхөн улсын төсөв биш хувийн хэвшилтэй хамтарч явуулах, гадаад, олон улсын хөгжлийн түнш байгууллагуудтай бас хамтарсан судалгаандаа илүү анхаарч ажиллах юм бол энэ санхүү төгсөлтийн үр шимийг нь бол яг судалгаа хийж байгаа тухайн эрдэмтэд маань хүртээд бас цалингийн орлогоороо өөрийнх нь бас ажиллах баталгаа нь бас сайжирна гэж үзэж байгаа. Зөвхөн төсвийн цалин биш бусад.

С.Зулпхар: Эдийн засгийн үр өгөөж хэрхэн гарч байгаа вэ гэсэн асуулт байна. Судалгаа шинжилгээний ажлууд хийгдэж байна. Үүнээс эдийн засгийн ямар үр өгөөж гарч байна гэсэн ийм их тодорхой асуулт байна. Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны дарга Б.Бат-Эрдэнэ хариулна.

Б.Бат-Эрдэнэ: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Мөнхтуяа гишүүн асуултад хариулъя. Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны дарга Бат-Эрдэнэ. Манай Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангаас бол эрдэм шинжилгээний ажил нь жилдээ 200-250 орчим төсөл санхүүжигдэж 200-гаад төслийн үр дүн мэдээллийн нэгдсэн санд ордог. Энэ орсон үр дүнг бид нар мэдээллийн сангаараа дамжуулан төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудыг мэдээллээр хангаж ажилладаг. Эндээс гарч байгаа үр дүн, патент, зохиогчийн эрх, бүх үр дүнгээ мэдээллийн сангаараа дамжуулаад төрийн өмчийн болон төрийн өмчит орон нутгийн байгууллагуудад мэдээллээр хангаж ажилладаг. Одоо цаашдаа бол нийтэд мэдээллээр хийхээр цахим системээр бол хөгжүүлэлт явж байгаа.

Үр дүнгийн хувьд бол жилдээ манайх 200-гаад тайлан, эрдэм шинжилгээний тайлан хүлээж авдаг. Үүнд нь бол дагуулаад олон улсын сэтгүүл.../минут дуусав./

С.Зулпхар: Хариулт гүйцээе.

Б.Бат-Эрдэнэ: Олон улсын сэтгүүлд импакт фактор өндөртэй сэтгүүлд өгч байгаа өгүүллийн тоо, эрдэм шинжилгээний дотоодод хэвлүүлж байгаа өгүүллийн тоо, патентын тоо, оюуны өмчийн тоогоор хязгаарлаж үр дүнгээ авч мэдээлж яваа.

С.Зулпхар: Мөнхтуяа гишүүн тодруулъя.

Ц.Мөнхтуяа: Ер нь энэ нөгөө урт хугацааны төлөвлөгөө, 2050 Алсын хараа гээд л их гоё гоё нэртэй ийм уриа төдий юмнууд чинь ингээд ажил хэрэг болохгүй байгаа нь үнэхээр харамсалтай байна л даа. Нөгөө төсөвтөө багтаана, төсөвтөө захирагдана гээд л ингээд л нөгөө хүмүүсийнхээ эрхийг ноцтой зөрчөөд яваад байгаа байхгүй юу. Яг үнэндээ бол Монголд хамгийн өндөр цалинг энэ шинжлэх ухааны эрдэмтэн, судлаачид авч байх ёстой гэж би ойлгодог.

Гэтэл өнөөдөр нөгөө эрдэмтэд нь цалин нь бага учраас арга буюу хөөрхий хувийн хэвшил, гаднын орныг зорьж байгаа. Энэ бол үнэхээр харамсалтай. Энэнтэй ч холбоотой манай улсын хөгжил ер нь уяатай байгаа байх гэж би ойлгож байгаа. Тэгээд энэ эрдэм шинжилгээний ажилтнуудынхаа орон сууцад хамруулах ийм хүсэлтүүдийг хүлээж авч байна л гэж байна л даа. Гэтэл өнөөдөр нөгөө орон сууцжуулалт дээр чинь 30-хан метр квадрат орон сууц

С.Зулпхар: Мөнхтуяа гишүүний цагийг нэмж өгье.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ц.Мөнхтуяа: 30м² орон сууцад та нар орж амьдрах уу? Ийм юм ингээд төр засаг хийчхээд төрийн албан хаагчдаа доромжлоод сууж байна л даа. Яг үнэндээ харамсалтай байна. 30 метр хүртэл, квадрат метр хүртэл байранд оруулна гээд би тэр хуулийн төслийг нь уншсан тэр Бат-Амгалан сайдын оруулж ирж байгаа. Энэнд эрдэм шинжилгээний ажилчид орж амьдрах уу 30м² хүртэл байранд? Ийм хариуцлагагүй юмнууд хийгээд ингээд хаа хаанаа ажил хийсэн нэртэй нэр зүүгээд яваад байгаа байхгүй юу. Тэгээд ер нь бол энэ 20 байр ухарснаа ч хөөрхий яаж тайлбарлах вэ дээ. Төсөв нь ийм бага юм чинь ухрахаас ч яах вэ. Би бол эрдэмтдээ өмөөрч байна, өрөвдөж байна яг үнэндээ. Манай төрийн бодлого өөрөө ийм буруу учраас бүх юм нь уруугаа харчихсан ийм л байгаа. Тэгээд нөгөө хойд хормойгоороо урд хормойгоо нөхнө гэдэг шиг л хөөрхий ёстой нээрээ ялт ч үгүй л энэ ажил хийж байгаа л хүмүүс шүү дээ.

С.Зулпхар: Мөнхтуяа гишүүн бас санал хэлэх үедээ ахиад саналаа бас тодорхой хэлээрэй. Яг саяын Мөнхтуяа гишүүн их тодорхой юм асууж байна шүү дээ. Мэдээж Эдийн засаг, хөгжлийн яам бол энийг бодлогыг тодорхойлоод оролцож байгаа саяын төрийн албан хаагчдын мөн дотроо эрдэм, шинжилгээний ажилтан албан хаагчдын цалинтай холбоотой, тэр ипотекийн зээлд хамрагдахтай холбоотой чиглэлээрх асуулт яваад байна. Энэ дээр Батхүү дарга ер нь хариулт өгсөн нь зөв.

И.Батхүү: Мөнхтуяа гишүүний асуултад түрүүн бас хариулсан. Одоогийн байдлаар 15 хувиар 26 ондоо нэмчхээд явж байгаа. 3.5 сая төгрөгт дунджаар хүргэе гэдэг зорилтоо тавиад Үйлдвэрчний эвлэлтэйгээ тохирчихсон ажиллаж байгаа. Тодотгол бол ирэх жилийн төсөв дээр энэ тал дээр анхаарч ажиллана. Таныг бас энийг дэмжиж өгөөч гэж хүсье.

Ипотекийн зээл, орон сууцын зээлтэй холбоотой асуудлын хувьд манай яг салбарын асуудал хариуцсан газрынхан судалгаа хийсэн байна. Энэ дээр бол нийт эрдэмтэн, судлаачдын 85 орчим хувь нь бол өөрийн гэсэн орон сууц ямар нэгэн байдлаар зээлээр хангагдсан. 25 орчим хувь нь бол өөрийн гэсэн орон сууцгүй байгаа учраас ирсэн судалгаа, хүсэлтийн дагуу биднүүс бас боломжийг нь хангах үүднээс ийм холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаад явж байна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариултаа авч дууслаа. Одоо танилцуулагдсан асуудал ба асуулт, хариулттай холбогдуулаад Их Хурлын гишүүд үг хэлнэ. Үг хэлэх гишүүд нэрээ өгье.

Рэгдэл гишүүнээр тасалъя. Рэгдэл гишүүний микрофоныг өгье.

Д.Рэгдэл: Яамны танилцуулга их ойлгомжтой тодорхой байна. Яах вэ бид нар чинь нөгөө 26, 30 оны үндсэн чиглэлээ баталчихсан учраас бас тодорхой зорилтууд бол тоогоор хэмжиж болохуйц ингээд гаргаад байгаа нь их сайн хэрэг. Тэгэхдээ бид нар гол юмандаа төвлөрмөөр байгаа юм. Гол юм.

1 дүгээрт, энэ цалингийн асуудал. 26 онд 15 хувь нэмэхэд яам оролцоогүй оролцоогүй. Гэхдээ 15 хувь нэмэгдсэн.

2 дахь гол асуудал бол энэ орон сууцын асуудал байгаа. Сая Мөнхтуяа гишүүн ч хэллээ. Одоо академийн мэдлийн жаахан газар бий. Тэгээд тэн дээр

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

орон сууц бариулах гэх дээр зэрэг Засгийн газрын 2010 оны тогтоолоос болоод саатаад байгаа юм.

Тэгэхээр зэрэг Батхүү дарга энийг та тэр орон сууцын газрын шийдээд өгөх хэрэгтэй байгаа юм. Яамнаас хөөцөлдөхгүй бол академийн эрх мэдэл дутаад байгаа. Газар нь байж байгаа. Энд орон сууц барих юм бол 400 гаруй эрдэм, шинжилгээний ажилтан бол орон сууцгүй байна. Тэд нар бол ороод тэнд нь 600 хүнээ орон сууц барих боломжтой ийм боломж бол байгаа. Энийг бол ашиглавал их сайн юм байгаа юм.

Бас нэг чухал асуудал бол энэ Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан 2012 онд үндсэндээ эдний эрдэм шинжилгээний зардал 11, 12 тэрбумд хүрчихсэн. Одоо тэндээ хүрэхгүй яваад байгаа юм. Тэгэхээр 2012 оноос хойш энэ чинь 26 он гэхэд 14, 5-н жилийн хугацаанд ДНБ чинь бараг 10 гаруй өсчихсөн. Тэр эрдэм шинжилгээний ажлын зардал ерөөсөө өсөөгүй. Тэгэхээр энэ дээр энэ 27 оны төсөвт манай яам онцгой анхаарч лоббидож явж байж эдний зардлыг дор хаяж 3 дахин нэммээр байгаа юм 30 тэрбумд. Тэгж байж энэ чинь бодитой үр дүнгүүд гарч ирэх юм байгаа юм.

Тэгэхгүй бол яах вэ энэ чинь 2001 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас хөгжиж байгаа орнуудын Засгийн газарт зөвлөмж гарсан юм. Тэр зөвлөмж нь бол энэ салбарынхаа зардлыг ДНБ-ий 1 хувьд хүргэж байж тэр салбараасаа үр ашгаа, эдийн засгийн хөгжил, бодитой үр дүн авчирна гэсэн зөвлөмж 25 жил болж байгаа юм. Манайх одоо 1 хувьдаа хүрээгүй 26 онд бол яах вэ рекорд өндөр хувьд хүрсэн. Тэр нь бол ДНБ-ий 0.16 хувь. 90 онд бид нар 1 хувиа санхүүжүүлж байсан юм 90 он хүртэл ДНБ санхүүжүүлж байсан. Тэгэхээр одоо бол 01 хувьтай байна гэж юу гэсэн үг вэ? Одоо дэлхийн дунджаас бид нар 20 дахин доогуур байна гэдэг чинь энэ салбараас бодитой томоохон үр дүн ерөөсөө хүлээх ямар ч арга байхгүй. 2 дахь.

3 дахь гол асуудал энэ Үндэсний шинжлэх ухаан, технологийн санг Засгийн газрын тусгай сангийн хуулиас гадуур гаргамаар байгаа юм. Дэлхий дээр улс орнуудад байдаг ийм сангууд ийм манай энэ Засгийн газрын тусгай сангийн хууль шиг хуульд захирагддаггүй тусдаа зохицуулалттай явдаг юм. Энийг бас Эдийн засаг, хөгжлийн яам Үндсэн хуулийн 38.2-т заасан нэгдсэн бодлогоо гаргахдаа энэ хүрээнд энэ арга хэмжээг бас хөөцөлдөж явмаар байгаа юм. Энэ биеэ даасан сантай шууд Ерөнхий сайдын харьяалалд ч юм уу ингэж явахгүй бол энэ чинь өнөө Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай адилхан тийм болчхоод байгаа шүү дээ. Тийм байж хэрхэвч болохгүй. Энэ дээр бид нар аль болохоор цаг алдалгүй явмаар байгаа юм.

4 дэх бид нарын чухал асуудал бол тэр саяын индексүүд ярилаа. Инновацын индекс, мэдлэгийн индекс. Энэ дээр бид нар байр ахиулах боломжтой. Ер нь байр ахиул боломжтой. Гэтэл саад болж байгаа том хүчин зүйл бол судалгаанаас гарч байгаа бодитой үр дүнг авч хэрэгжүүлдэг үйлдвэрлэлийн технологийн суурь нь хөгжихгүй байгаа юм.

Тийм учраас энэ шинжлэх ухааны салбарт парк, шинжлэх ухааны парк байгуулж өгөөд тэр.../минут дуусав./

С.Зулпхар: Цаг нэмж өгье саналыг бүрэн сонсьё.

Д.Рэгдэл: Тэр, энэ мэдлэгийн индексийг нэмэгдүүлэхэд хэцүү болох боловч яагаад гэвэл тэр технологийн суурийг сайжруулахгүйгээр, тийшээ бодитой ажилд нэвтэрч орохгүйгээр бодитой яг барьж авах үр дүн гарахгүй байгаа юм. Тэгэхдээ зэрэг үйлдвэрийн технологийн баазын суурийг сайжруулна гэдэг нь Монгол Улс өөрөө технологи хөгжүүлэх бодлоготой байх ёстой. Одоо шинжлэх ухаан, технологи дамжуулах тухай хууль гараад миний бодлоор бол энэ чинь 2008 онд ч, бараг 7 онд ч батлагдчихсан бил үү ерөөсөө хэрэгжихгүй ингээд яваад байдаг юм тэр.

Тэгэхээр Шинжлэх ухаан, технологи дамжуулах тухай технологийн үнэлгээ энэ тэрнийхээ асуудлыг шийдээд ингээд технологийн бодлогоо өөрөө гаргаж авах нь маш чухал байна гэж ингэж хараад байгаа. Технологийн бодлого гэж ерөөсөө явахгүй. Эсвэл бид нар олон улсын жишгээр Шинжлэх ухааны тухай хууль гэж тусдаа хуультай байж болно. Олон улсад бол дандаа тэгж яваад байгаа.

Яагаад вэ гэвэл нөгөө технологи чинь салбар бүр дээр өөрийн юмнууд байж байдаг. Тэгэхгүй шинжлэх ухаан, технологи гэхээд технологийн талын бодлого, төлөвлөлт бүх юм байхгүй байхгүй яваад байгаа юм. Тэгэхээр энэ орон зайг бид нар олж авахын тулд нэг бол хурдан нэгдсэн бодлогоо гаргах, эсвэл шинжлэх ухааныхаа асуудлыг тусад нь тавиад бид нар дэлхийн мэдлэгийн санд оруулах хувь нэмрээ нэмэгдүүлээд хэсэг явъя гэж ингэж бодож, төлөвлөж явж болохоор санагдаад л байгаа юм. Тэгээд л хамгийн гол нь бид нар энэ үндсэн чиглэлд заасан ДНБ-ий 1 хувьд хүргэх асуудлыг л.../минут дуусав./

С.Зулпхар: Рэгдэл гишүүн санал хэллээ. Бусад гишүүд санал хэлэх гишүүд байна уу? Би тэгвэл саналыг бас нэгтгэж би хэлье. Бид мэдээллийг бол мэдээж хэрэг тодорхой мэдээлэл урьд нь ч гэсэн авч байсан манай дэд хорооны гишүүд шинжлэх ухааны хүрээлэнгүүдээр явж уулзсан. Хүрээлэнгийн бас удирдлагуудтай нэгдсэн байдлаар уулзалт, зөвлөгөөн бас зохион байгуулсан. Эдийн засаг, хөгжлийн яамтай бол бас зохих түвшинд бол тодорхой асуудлуудаар бас тодруулга авч байсан. Ингээд эхний зохих түвшний шийдвэрүүд гарсан. Тэр шийдвэр нь бол ямар ч байсан Рэгдэл гишүүн санаачилж, бид дэд хороогоороо бүрэн дэмжиж, мөн энэ жилийн төсөвт шинжлэх ухааны салбарын ажилтнуудын цалинг ямар ч байсан 15-аар нэмэгдүүлсэн. Гэхдээ энэ бол хангалттай биш. Яагаад ч хангалттай биш гэдгийг бол мэдэж байгаа.

Нөгөөтээгүүр жишээ нь тодорхой хуулийн төсөл орж ирсэн. Рэгдэл гишүүн, Уянга гишүүн нарын санаачилсан. Үүнийг бас дэд хороогоороо бид ажлын хэсэг гаргаад энэ хуулийн төслийг бол маш шуурхай батлуулсан. Зохих түвшинд шинжлэх ухааны байгууллагуудын судалгаа, шинжилгээний ажилд зохион байгуулахад хийхэд тулгарч байгаа зарим бэрхшээлүүдийг даван туулахад чиглэсэн хуулийн төсөл байсан.

Өнөөдөр бид мэдээлэл сонсож байна. Мэдээлэл бол зарим жишээ нь мэдээлэл бол угаасаа мэддэг зүйл. Зарим зүйл бол бас явцын гарч байгаа үр дүнгүүд, зарим зүйл бол цаашдаа шийдэх ёстой зайлшгүй асуудлуудын талаарх мэдээлэл байна. Энэ ч үүднээс шинж Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны гишүүдийн санаачилгаар бол бид бас тогтоолын төсөл гаргахаар бас бэлтгэл хангаж төрийн захиргааны төв байгууллага буюу Эдийн засаг, хөгжлийн яам бол

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

холбогдох шинэ төслийн саналыг боловсруулж ирүүлсэн байгаа. Энэ дээр бид бас ажиллах байх.

Одоо гишүүдийн хэлсэн саналтай холбогдуулаад би тодорхой зүйлүүдийг ярья. Энийг бид бас мэдээж цаашдаа тогтоолын төсөлдөө тусгах зүйлүүд ч байх шиг байна. Заримыг нь бол төрийн захиргааны байгууллага болон Шинжлэх ухааны академи, шинжлэх ухааны жишээ нь асуудал хариуцсан энэ сангийн удирдлагууд цаашдаа анхаарч таарах нь.

Бид бол энэ эрдэм шинжилгээ, судалгааны ажилтай холбоотойгоор салбарынхаа хүний нөөцийг бол онцгой анхаарахгүй бол болохоо байсан. Энийг бол олон нийт сайн мэдэж байх ёстой, манай бусад хууль тогтоогч нар ч гэсэн сайн мэдэж байх ёстой. Гайгүйхэн шиг шинжлэх ухааны байгууллагад бол гайгүйхэн шиг ажилтныг тогтоох ямар ч боломжгүй болчихсон. Сая Рэгдэл гишүүн хэлж байна. Мөнхтуяа гишүүн их тодорхой хэлж байна. Ийм цалингаар бол өндөр бэлтгэгдсэн эрдэм, шинжилгээний ажилтан бол тогтох боломжгүй юм байна. Үүнийг бид бол хувийн хэвшил рүү алдана. Яах вэ тэр бол дотооддоо алдаж байгаа бол бас хэрэг. Нөгөө бол бид гадагшаа алдаж байгаа. Тэр хүн бол эрдмийн ажлаа хийх гээд гадагшаа явчхаж байгаа. Гаднын томоохон хүрээлэнгүүд уриад ажиллуулчхаж байгаа. Нэн ялангуяа бол манай дунд насны эрдэм шинжилгээний ажлууд дотор гадаадад их гарсан байна. Энийг бид оюун санааны дайжилт, нүүдэл гэж хэлдэг.

Бид ингээд дайжилт, нүүдэл хийгээд байх юм бол бид бусад салбараа хөгжүүлэхэд шаардлагатай эрдэм шинжилгээний ажилтнуудаа алдсан байх юм бол төдий хэмжээгээр манай бусад салбарын хөгжил бол саардаг. Хөгжих боломж байсан бол тэр хөгжих боломжийг бид алдаж байна гэсэн үг.

Тэгэхлээр энэ дээр бид онцгой анхаарах нь. Захиргаа, төрийн захиргааны төв байгууллага бол өөрөө жишээ нь бодлогоо тодорхойлоод явж байгаа. Энэ дээр анхаарах нь гэж байгаа юм.

2 дахь зүйл энэ тоног төхөөрөмжүүд. Та бүхэн сая сонслоо шүү дээ. Үндсэндээ бол 80 хувь нь хугацаа нь, хугацаа өнгөрчихсөн. Энэ өнөөгийн цаг үетэй харьцуулах юм бол 70, 80-аад оны үеийн лабораторийн тоног төхөөрөмж хэрэглэж байгаа нөхцөлүүд ч байна. Зарим хүрээлэнгүүдийн өөрсдийн санаачилгаар заа бас тодорхой дэмжлэгээр, гадна, дотнын дэмжлэгээр бол шинэ төхөөрөмжтэй болсон хэлбэрүүд ч гэсэн байна. Өөрсдөө санаачилж бас хичээж байгаа зүйл бол байгаа. Энийг бол үгүйсгэж болохгүй. Гэхдээ энэ дээр гол анхаарах зүйл бол бид төрөөс анхаарах ёстой, төсвөөс анхаарах ёстой. Хувийн хэвшилтэй хамтарч энэ боломжуудыг нээх ёстой гэсэн.

Бид чинь шинэ зохион байгуулалтын тийм арга хэрэгслийг яриад байгаа шүү дээ. Арга замыг яриад байгаа юм. Тэрийгээ их шуурхай хийх ёстой юм байна. Энэ бол 2 дахь саналтайгаа уялдсан 3 дахь санал. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал.

Сая эхний, үр дүнгүүд гарч байна шүү дээ. Тодорхой лабораториудыг хувийн хэвшил ашиглаад тэгээд тэр дээр бол төлбөр төлөөд буцаад лаборатори өөрөө чадавхаа бэхжүүлэх боломж нээгдэж байна. Тэгэхээр бид иймэрхүү зүйлүүдийг ямар хууль саад болж байгаа юм. Тэр хуулийг нь бидэнд хэлээд бид тэрийг бол шийдэх ёстой бол та бүхэн саналаа шуурхай оруулаач гэж байгаа юм.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Би энийг Засгийн газрыг хэлж байгаа юм. Та бүхэн саналаа оруулаач гэж байгаа юм. Тэнд лаборатори дээр бол олсон мөнгийг бол ерөөсөө бид ийм төсөв рүү буцаагаад аваачаад хийдэг байдалтай биш тухайн лаборатори нь өөрийнхөө чадавхыг бэхжүүлэх энэ чиглэлээр нь бүрэн ашиглах ёстой шүү.

Сүүлдээ мөнгө ордоггүй байхад нь тэрийг нь аваачаад нэгдсэн төсөв рүү татдаг ийм орлого маягтай үзэж байгаа нь өөрөө буруу. Шинжлэх ухаан хэдий хэмжээний бид анхаарал хандуулж төсөв өгнө төдий хэмжээний үр дүн гардаг ийм л зүйл шүү дээ. Тэгэхээр энэ дээр та бүхэн бас анх анхаарч өгөх ёстой юм байна гэсэн ийм зүйлийг зориуд хэлье гишүүд хэлж байгаа учраас.

Сая Хосбаяр гишүүн хэлж байна. Ер нь бол нөгөө хөгжлийн бодлого төлөвлөлтөд шинжлэх ухааны салбарын жишээ нь та бүхэн сайн сонсох ёстой шүү гэж. Эхний санаачилгууд гараад, эхний үр дүнгүүд гарч байна. Гэхдээ энэ бол бас хангалттай бол биш гэж хэлж байгаа бол бид илүү жишээ нь бодлогын түвшинд бол байнга оролцуулах, шаардлагатай түвшинд нь бол энэ чинь бас цаана энэ ажил чинь өөрөө бас хөлс мөнгөтэй гэдгийг бодож байх ёстой. Шинжлэх ухааны жишээ нь салбарын ажилтнууд ирээд саналаа хэлж байгаа бол тэр дээр нь зохих ажлын хөлсийг нь өгч байх ёстой. Зүгээр ирээд саналаа хэлж болно.

Нөгөөтээгүүр нарийн жишээ нь тооцоолол хийх, нарийн жишээ нь шинжлэх ухааны жишээ нь үндэслэлүүдийг гаргах дээр бол энэ ажил гэж үзэж энэ дээр бас ажилладаг олон улсын жишиг байгаа шүү дээ. Тэр жишиг рүүгээ л ороорой. Тэгэхгүй бол манайд бол ингээд ийм сайн дурын байдалтай хийдэг. Тэгээд сайн дурын байдалтай хийсэн ажлын чинь үр дүн өөрөө бас бүрэн гардаггүй ийм байдал байгаа учраас ийм санал хэлж байна.

Мөнхтуяа гишүүн болон Рэгдэл гишүүн нарын санал их чухал. Яг тодорхой зүйл хэлж байна. Бид хэрвээ хувь руу дотоодын нийт бүтээгдэхүүн 1 хувь руу бид шинжлэх ухааны салбарын зардлыг хүргэнэ гэдэг зорилт байгаа бол, уг нь 2 хувь шүү дээ. Гэхдээ бид эхлээд 1 хувь руу хүрье гэж байна шүү дээ. Одоо 0.1 байгаа учраас. 2027 онд яах юм, 2028 онд яах юм гэдгийг их тодорхой бид бол оруулж ирэх ёстой болчхоод байна.

Яг энэнтэй уялдсан байдлаар бид ер нь шинжлэх ухааны салбарт гаргаж байгаа зардлаар бид ер нь шинжлэх ухааны салбарт гаргаж байгаа зардлаа ер нь бүрэн тооцож чадаж байна уу гэдэг бас зүйл гарч ирж байгаа юм. Бид зарим төрийн байгууллагууд дээр хийгдэж байгаа судалгаанууд, бодлогын судалгаанууд энэ чинь шинжлэх ухааны нэг хэсэг шүү дээ. Тэрийг тооцох ёстой юу гэдэг бас тооцооллын тийм аргачлал гарч ирэх нь.

Нөгөөтэйгөөр жишээ нь төсвийн үр дүнгээр ямар үр өгөөж биеж бий болж байгаа юм бэ? Энэтэй бас холбоотой учраас бид энэ асуудал дээр анхаарах нь. 27, 28 онд яаж бид энэ ДНБ-ий тодорхой хувьд шинжлэх ухааны зардал нэмэгдээд явж байна вэ гэдгийг бол нарийн тооцож боломжоороо гэсэн үг шүү дээ ингэж оруулах чиглэлд бол анхаарах ёстой юм байна гэсэн ийм чиглэлийг гишүүд хэлж байна.

Дараагийн чухал санал гарч ирж байна. Тогтоолд бол бид мэдээж хэрэг анх орж ирэхдээ төрийн захиргааны төв байгууллага нь өөрөө 50 хувь гэж оруулж ирсэн юм. Бид энд тэндээс бас энийг тодруулаад бас тооцоолол дээр бол 30-аас

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

илүү байж болохгүй гэдэг чиглэл одоо ирсэн. Гэхдээ нэгэнтээ эндээс бол гишүүд санал гаргаж байгаа бол их тодорхой санал гаргаж байна шүү дээ. Тийм бол бид тогтоол дээр саяын тэр 30 гэж зассаныг бол буцаад бид яаж оруулах вэ гэдгийг бол гишүүд маань өөрсдөө саналаа өгөх байх гэж бодож байна. Энэ дээр Мөнхтуяа гишүүн бол өөрөө их сайн мэдэж байгаа.

Ялангуяа энэ чинь үйлдвэрчний эвлэлтэй бол их тодорхой тохирчихсон 3 талт хэлэлцээр байгаа байхгүй юу. Хэлэлцээрийн түвшинд байгуулчихсан юм байгаа бол та үйлдвэрчний эвлэлд байсан энэ хэлэлцээрийг биелүүлэх чиглэлээр талууд үүрэг хүлээдэг гэдгийг сайн мэдэж байгаа учраас энэ дээр бид нэгэнтээ тодорхой тусгасан байгаа бол тэрийг яах вэ гэдгийг дэд хороон дээрээсээ бид тогтоол дээрээ саналаа оруулаад оруулаад байнгын хороо руу оруулах боломжтой. Энэ дээр жишээ нь та бүхэн саналаа өгөөрэй гэж байгаа юм.

Ингэж байж яг энэнтэй уялдсан байдлаар 3.5 саяд хүргэх зорилт тавьсан. Гэхдээ бид мэдэж байгаа энэ шинжлэх ухааны жишээ нь салбарын ажилтнуудын нэн ялангуяа эрдэм шинжилгээний ажилтнуудын тодорхой ажил хариуцаж байгаа улсуудын цалин бол зохих түвшинд өндөр байдаг. Тэр жишгээ барихгүй бол саяын ажилтнуудыг хүний нөөцийг тогтоох боломжгүй. Энийг онцгой анхаарах ёстой юм байна. Тэгэхлээр энэ дээр бас та бүхний санал гарах нь. Их олон ажилтан бол биш байгаа юм. Яг ингээд ерөнхий тоо гаргахад тэр дотор чинь яг шинжлэх ухааны ажилтан нь 1700, бусад лаборатори, техникийн ажилтнууд бас байгаа. Тэд нарыгаа оролцуулаад нарийн тооцоон тооцооллыг та бүхэн хийгээч гэж байгаа юм. Зарим зүйлийг бид бол ингээд нарийн тооцоон дээр үндэслэлээр нь ярих юм бол цаашаа хэрхэн дэмжигдэх вэ гэдэг тооцоолол бас гардаг учраас энийг та бүхэн хийж өгөөч гэж байгаа юм.

Судалгааны үр дүнгийн өгөөжийг бол их тодорхой яримаар байна. Судалгааны үр дүнгийн өгөөжийг бол мэдээж хэрэг бид эдийн засгийнх нь үр өгөөжийнх нь талаас бас зохих түвшинд тооцож гаргаж баймаар байна. Энийг уг нь анхнаасаа бид ярьж байсан.

Нөгөөтээгүүр яах вэ энэ чинь шинжлэх ухаан бол дандаа эдийн засгийн үр өгөөж биш, шинжлэх ухаан, сургалтын үр өгөөж гэж бас гардаг. Тэрийгээ бас давхар бид тооцож байх ёстой.

Магадгүй нээлт хийчихсэн, патент хийчихсэн, тэрийг манайд нэвтрүүлэх боломжгүй ч гэсэн энэ бол одоо бусад улс орнуудад ашиглаж болдог патентын түвшний асуудал байдаг. Томоохон бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл бол өөрөө жишээ нь шинжлэх ухааны жишээ нь түвшнийг өргөдөг, сургалтын жишээ нь түвшнийг өргөдөг гээд ингээд энэ зүйлээр нь бид бол бас нөгөө тайлагналтаа их тийм тодорхой болгож, арга зүйгээ их тодорхой яримаар юм байна.

Тэгэхгүй бол энэ чинь ингээд л баахан тайлан гарчихсан байдаг. Юунд ч хэрэг болдоггүй юм шиг бас бид төсөөлөх тал бол бий. Бүрэн ойлголтгүй бол.

Нөгөө талдаа бас тийм тал байгаа бол тэрийгээ ч гэсэн анхаарч таарна. Нэн ялангуяа жишээ нь Бат-Эрдэнэ дарга а нэг судалгаа 10-19 саяар хийгдэж байна гэдэг бол ер нь бид тухайн судалгааны өртгийг зөв тооцож судалгаа хийлгэж байна уу гэдэг асуулт гарч ирж байгаа байхгүй юу. Зарим лабораторийн судалгаа чинь маш өндөр өртөгтэй шүү дээ. Зарим хээрийн судалгаа чинь маш өндөр өртөгтэй.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэгж байж тэр судалгааны үр дүн гарах ёстой учраас бид ингээд олон хүнд өгөх олон хүрээлэнд өгөх гэж байгаа юм шиг болгож байхаас 1 дүгээрт зардлаа нэмнэ.

2 дугаарт, яг өртгөөр нь санхүүжүүлж байж энэ шинжлэх ухааны үр дүн гардаг гэдэг рүү бас орох ёстой шүү гэж байгаа юм. Энийг бол бас яах вэ энд сууж байгаа багш, судлаач нар учраас бид бол ерөнхийдөө төсөөлж байгаа учраас хэлж байгаа юм гэж байгаа юм. Энэ асуудлыг та бүхэн онцгойлон анхаарч таарах нь гэж байгаа юм. Орон сууцтай холбоотой асуудал дээр энэ яах вэ тогтоолд бол тодорхой санал байсан. Энэ саналыг гишүүд маань, гишүүдэд би бас ахиад танилцуулна. Тэр бол яах вэ Шинжлэх ухааны академийн өөрийнх нь жишээ нь эдэлбэр газарт байгаа тэр нөхцөл байдлыг ийг жишээ нь бид зөвшөөрлийг нь аваад орон сууцын жишээ нь асуудлаа шийдье гэсэн санал орж ирсэн. Энийг бид бас зохих байгууллагатай нь яриад бол хассан юм байгаа юм.

Гэхдээ энийг хасах эсэх нь бол нэг асуудал. Буцаад энийг оруулах ёстой бол та бүхний саналаас бол тодорхой санал гаргах юм шиг байна. Энэнтэй холбоотой төрийн захиргааны байгууллага нь бол өөрөө бол дэмжиж оруулж ирсэн. Батхүү даргаас, сайдаас ирсэн бичиг дээр бол дэмжиж оруулж ирсэн юм. Тэгэхээр энийг бид үнэхээрийн оруулах ёстой бол оруулна.

Нөгөөтээгүүр бол бас саяын Мөнхтуяа гишүүний хэлж байгаа бас дараагийн хуулиуд дээр бид бүгдээрээ анхаарч таарах нь байна шүү дээ. Анхаарч таарахаас гадна ер нь зүгээр энэ төрийн албан хаагч, түүн дотор эрдэм шинжилгээний ажилтнуудын тэр орон сууцтай холбоотой квотын асуудал дээр бид бас анхаарал хандуулах бол тэр үед энэ бас яригдах нь гэсэн ийм бодолтой байна.

Тэгээд академичийн хэлсэн тэр Шинжлэх ухаан, технологийн санг бол энэ Засгийн газрын тусгай сангуудын түвшинд байх юм уу эс үгүй бол угаасаа нөгөө нийтлэг олон улсын жишгээрээ байх юм уу гэдэг асуудлыг бас та бүхэн бидэнд судалж шийд хэлнэ биз тийм ээ. Гэхдээ энэ бол бас нарийн хуулийн асуудал учраас бид судалж байж ярьдаг зүйл байгаа гэдгийг хэлье.

Ингээд бид бол мэдээллээ ямартаа ч сонслоо. Энэ бол шинжлэх ухааны салбарыг бол манай гишүүд бол бүхий л түвшинд, бодлогын, төсөв, зохицуулалтын түвшинд бол дэмжинэ гэдгээ бол байнга илэрхийлж байсан. Ямар ч байсан энэ жилийн хугацаанд, энэ жилийн намрын болон хаврын чуулганы хугацаанд бол манай дэд хорооны гишүүд бол нэг хууль батлуулсан. Одоо тогтоолын төсөл бол үндсэндээ гарна. Гэхдээ тогтоолын төсөлтэй бид танилцана.

Ингээд явах юм бол эхний алхмууд гарч байна. Хүрээлэнгүүдтэй бол ойрхон очиж уулзаж байгаа. Зарим асуудлуудыг бид ажил хэргийн шугамаар бол шийдээд жишээ нь яамтайгаа яриад ингээд явж байгаа. Яам ч гэсэн авах ёстой бодлогын дэмжлэгийг бол бидэнд бол илэн далангүй хэлээд явж байгаа шүү гэдгийг хэлье. Ингээд эхний байдлаар бол дараах жишээ нь мэдээлэлтэй холбогдуулаад дараах саналуудыг та бүхэнд хүргүүлж байна.

Танилцуулгатай холбогдуулан үг хэлж дууслаа. Одоо 2 дахь асуудал руугаа ор орёе. Би жишээ нь эндээс та бүхэнд тараагдсан байгаа байх. Тогтоолын төсөл очсон байгаа. Тогтоолын төслийг бол та бүхэн угаасаа эхнээс бас та бүхний хэлж байсан саналууд бий. Саяын та бүхний бас яригдсан мэдээлэлтэй холбогдуулж хэлсэн санал, асуусан асуулттай холбогдуулаад бид энэ тогтоолын хүрээнд бол

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

бас нэмж хасах боломж бол бий. Энэ бол та бүхний бүрэн эрхийн асуудал. Тэгэхлээр бид бол тогтоолын төслийг бол уншиж танилцуулах бол шаардлагагүй байх. Тэгээд би эхлээд тогтоолын төсөлтэй холбогдуулаад та бүхнээс гишүүдээс асуулт байвал асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя.

Ажлын хэсэг шаардлагатай бол нэмэлт мэдээлэл өгөх үүднээс байж байна. Гишүүд асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье.

Асуулт асуух гишүүн байхгүй. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлнэ. Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Улсын Их Хурлын гишүүн Рэгдэлээр тасаллаа. Рэгдэл гишүүн үг хэлнэ.

Д.Рэгдэл: Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулахад оролцоод явж байсан болохоор их асуулт асуух юм юу байх вэ. Тэгэхдээ бид нар энэ тогтоолын төсөл дээр 9 дээр заачихсан байж байгаа юм. Цаашлаад явж байгаад 12 дээр заачихсан байж байгаа энэ багаж, тоног төхөөрөмжийн асуудал байгаад байгаа юм. Багаж, тоног төхөөрөмжийн асуудал ороод ирэхтэй зэрэг Тендерийн хуулиар ингээд явдаг. Тэгээд сүүлийн жилүүдэд бол бид нар чинь тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтаас үндсэндээ 7.5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж авч чадаагүй.

Яагаад вэ гэхээр зэрэг энэ чинь Төрийн хэмнэлтийн хуулиараа 05 дугаар сарын 31-нээр гэрээ хийгээгүй бол буцаагаад улсын орлого болгоод татаад авчихдаг. Тэгэхээр зэрэг энэ дээр одоо энэ Төрийн хэмнэлтийн хуулийн тэр 05 дугаар сарын 31 гэдэг энэ заалтыг бол манай Байнгын хороо санаачилж хөөцөлдөж энэ заалтыг нь өөрчилмөөр байгаа юм.

Яагаад гэвэл энэ чинь Монгол Улс даяар төсвийн жил чинь 01 сарынхаа 01-ээс эхлээд л 12 сарын 31-ээрээ дуусаад байхад худалдан авах ажиллагаа нь тал дундуур нь тасалдаг бол энэ ерөөсөө төрөөс хийж байгаа тодорхой хэмжээний луйвар явдаг. Тэгээд Төрийн хэмнэлтийн хуулийн тэр 05 сарын 31 гэдэг заалтын дараа энэнээс хэмнэгдсэн мөнгийг зарцуулахгүй гээд биччихсэн байгаа юм. Энэ юу гэсэн үг вэ? Буцааж хурааж авчхаад зарцуулахгүй байж болдог юм уу үгүй юү? Энийг чинь мэдэхгүй.

Тийм учраас би бол дэд хорооны дарга доктор Зулпхараас хүсэлт тавья гэж бодож байгаа юм. Төрийн хэмнэлтийн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг цөмөөрөө санаачлаад намрын чуулганд өргөн барья. Тэгээд энэ их саад болж байгаа.

Энэ тогтоолд бол машин, тоног төхөөрөмжтэй холбоотой бас зөв зөв заалтууд орсон. Зарим хүрээлэнгүүд Төрийн хэмнэлтийн хуулиас болоод гадаадын төслийн хөрөнгөөр авсан машинаа хүртэл хураалгасан. Дэмбэрэл академич бол машинаа хураалгасан. Гаднын төслөөр орж ирсэн машиныг Төрийн хэмнэлтийн хуулиар төр хурааж авч байгаа юм. Ийм юм ерөөсөө хэрхэвч байж болохгүй.

2 дахь юм бол ингээд бид нар мэдээж Төрийн хэмнэлтийн хуулиа бол баримтлаад ингээд явалгүй яах вэ. Одоо тэгсэн чинь машин хураадаг эрдэм шинжилгээний байгууллагууд чинь машин эзэмших эрхгүй болчихоод түрээсээр

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

машин аваад явъя гэхдээ зэрэг 1 жилд машин авах мөнгөөрөө хөдөө ажиллаад ингээд дуусаад байдаг. Тийм учраас эрдэм шинжилгээ тэр машин, унаа хэрэглэдэг тухай Төрийн нэмэлтийн хуульд байгаа байгууллагуудыг жагсаачихсан. Тэр жагсаалтад эрдэм шинжилгээний хүрээлэнг оруулчих гэх мэтийн энэ саналуудыг цөмөөрөө нийлж байгаад өргөн барья. Баярлалаа.

С.Зулпхар: Рэгдэл гишүүнд баярлалаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад бас тодорхой саналуудыг нэмж оруулж байна. Зөвхөн тогтоолын төсөлтэй холбогдуулаад биш энэ манай дэд хорооноос цаашид санаачлаад холбогдох хуулиуд дээр Худалдан авах үйл ажиллагааны тухай хууль болон Төрийн хэмнэлтийн хууль дээр бол тодорхой жишээ нь нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр хуулийн төсөл санаачилъя гэж. Энэ хуулийн төслийг бол бид санаачлах бол бид санаачилга гаргаад явъя. Таны санаачилгыг бол бүрэн хүлээж авч байна.

Нөгөөтээгүүр бас мэдээлэл болгоё. Яг Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль Засгийн газраас ороод ирчихсэн хэлэлцүүлж байна яаралтай горимоор. Үүнтэй жишээ нь зэрэгцүүлсэн байдлаар мөн адил жишээ нь Бизнесийн эрх чөлөөний, Засгийн газрынх Бизнесийн эрх чөлөөний тухай хууль, Ардчилсан намынх бол Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль юм. Энэ 2 хуулийг нэгтгээд ажлын хэсэг бол ажиллачихсан бэлэн болгочихсон байгаа. Энэ хүрээнд хүрээнд мөн яригдсан зүйл юм.

Нэн ялангуяа тэр тоног төхөөрөмж худалдаж авахтай холбоотой асуудал дээр хугацаа заадаг. Тэр бол буруу байна. Хугацааг бол бүүр санхүүгийн жил эхэлснээс авхуулаад энэ явдаг байвал зөв өө гэж. Тоног төхөөрөмж яагаад гэвэл захиалах, авах, авчрах, угсрах гэдэг ч юм уу энэ өөрөө үйл явц бол их удаан өрнөдөг учраас нарийн тоног төхөөрөмжүүдийг хэлж байна шүү лабораторийн ч гэдэг юм уу шинжилгээний энэ үүднээс зөвхөн энэ бол шинжлэх ухааны салбарын биш бусад салбарууд дээр мөн адил, сургалтын байгууллагууд дээр ч мөн адил зарим байгууллагууд дээр.

Тэгэхлээр бид нөгөө бодит байдлаа жишээ нь бүрэн үнэлж энэний дагуу хурдан өөрчлөлт хийхгүй бол болохоо байж байна гэдэг саналууд гарсан. Би бас ажлын хэсэгт байгаа учраас энэ саналыг бол дэмжсэн. Энэ дээр Батхүү дарга маань бас та өөрөө бас энэ асуудал энэ хуулийг боловсруулах чиглэлд оролцоод явж байгаа учраас анхаараач гэж байгаа юм.

Шаардлагатай ямар хууль байна бид хурдан өөрчилъе. Бид энэ эдийн засгийнхаа хөгжлийг өөрсдөө боомилсон баахан хуультай, хөгжлөө боомилсон баахан хуультай байх юм бол тэрийгээ өөрчлөх эрх нь бидэнд байгаа шүү дээ. Энэ талаас нь бид ажил хэрэгч жишээ нь хандаж энэ асуудалд оролцъё гэж байна. Таны хэлсэн саналыг бол хүлээж авч байна.

Нөгөөтээгүүр бас Батхүү дарга болон манай академийн Ерөнхийлөгч, сангийн захирал байгаа дээр тогтоолын төсөлд сая бол гишүүдийн хэлсэн саналыг тусгая. Та бүхний бас оруулж ирсэн саналуудыг бид ингээд тодорхой төрийн захиргааны байгууллагаас санал аваад ингээд түр хасчихсан байгаа шүү дээ. Энэ чинь төсөл хэлбэртэй. Тэгэхлээр тэрийг хасахгүй байх үндэслэлийг та бүхэн бас гаргаад ирээч гэж байгаа юм.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Нэн ялангуяа сая цалин хөлстэй холбоотой маш тодорхой зүйл байна. Тэр нийгмийн асуудлыг шийдэхтэй холбоотой тодорхой зүйл байна. Нэмэлтээр орж ирж байгаа бас тодорхой асуудлууд байна. Энийг мөсөн бид ирэх долоо хоногт тогтоолын төсөл Байнгын хороогоор оруулах чиглэлтэй байгаа учраас энэ хүрээнд бид шуурхай ажиллая. Саналыг бол маргааш авмаар байна. Маргааш гэхэд авчихъя. Энэ ч их тийм том тогтоолын төсөл биш тодорхой тогтоолын төсөл учраас маргааш гэхэд саналаа аваад манай референт Энхмаа энд сууж байна. Энхмаа референтэд өгөөд, нэгтгээд тэгээд гишүүдэд яаралтай энийг тараагаад манай дэд хорооны гишүүдэд. Тэгээд дэд хорооныхоо гишүүдийн саналыг эргэж аваад бэлэн болгоё гэж байгаа юм. Ирэх долоо хоногийн хуваарьт оруулах чиглэлтэй байгаа. Тэгээд бид Байнгын хороон дээр дахиад уулзана. Тэр үед бол бид өөрсдөө тогтоолоо тал талаас нь бүрэн тайлбарлаж, ойлгуулж гишүүддээ бас танилцуулах энэ ажлыг энэ ажлыг хамтдаа хийнэ гэж бодож байна.

Ингээд бид тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо үг хэлж бас дууслаа. Хэлэлцэх асуудал дууссан тул Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа та бүхэнд. Баярлалаа гишүүд.

13.23 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР